



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/304

Сүхбаатар сум

### “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, “Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.1.7, 32.1.8, Улсын онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 04 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аяныг 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран маскаа зүүе, гараа угаая 2 дугаар аяныг /телевиз, радио, сонин, цахим хуудас/-аар сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг нийт аж ахуй нэгжийн удирдлагууд болон агентлаг, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Маскны чанар, ариун цэвэр, хэрэглээ болон хэрэглэсэн маскийг ил задгай хаяж байгаад хяналт тавих, тогтсон нэг хогийн саванд хийх, устгах ажлын хэрэгжилтэд хяналт тавин, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллахыг үзвэр үйлчилгээний газрууд болон хүнсний дэлгүүр, банк, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, төр төсвийн болон үйлчилгээний байгууллагын захирал, эрхлэгч, дарга нарт, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/ нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig202c\zahiramjA4.docx